



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 57242

Улаанбаатар хот

Д.Оюунтуяад сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10 дугаар зүйлийн 10.4, 10.6, 10.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Дашжамцын Оюунтуяа нь хуулиар хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эрхэлсэн ажилдаа хайнга хандсан болох нь Сэлэнгэ аймгийн прокурорын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаартай мэдэгдэл, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс албан тушаалын цалингийн хэмжээг гурван сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын ахлах бүртгэгч Д.Оюунтуяад үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Иргэний улсын бүртгэлийн газар /Т.Нармандах/, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /С.Оюун-Эрдэнэ/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН

142301226